


Хөрөнгө оруулалтанд бэлэн үү?

Европын Холбооны санхүүжилтээр бид Монгол улсын ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Баялаг Өлзий ХХК-д ТЭЗҮ судалгаа хийж, хөрөнгө оруулалт авахад нь тусалсан.



Монгол улсын ноолууран бүтээгдэхүүний компани

Бид Монгол улсын ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Баялаг Өлзий компанид үйл ажиллагааны зээл авч, үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжийг олгох дунд хугацааны бизнес хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахад тусалсан.

1991 онд Баянхонгор аймагт байгуулагдсан Баялаг Өлзий ХХК нь Монголын хөдөө аймгууд, нийслэл хот болон Хятадын хооронд хөдөө аж ахуйн түүхий эд бүтээгдэхүүний худалдаа хийж анх эхэлж байжээ. Тэр үеэс хойш Баялаг Өлзий компани Улаанбаатар хот дахь үйлдвэртээ 48 хүн ажиллуудаг, 1.3 сая еврогийн борлуулалтай компани болон хөгжсөн.

Тус компани ямаа, сарлаг, тэмээний ноосыг самнаж экспортлодог. Тус компанийн бэлэн бүтээгдэхүүнүүд (нэхмэл свитерэн цамц, пальто, хүрэм, хөнжил болон аксесуар, г.м) нь дотоодын болон гадаад зах зээл дээр нэр хүндтэй байдаг. Тус компанийн бүтээгдэхүүн нь компанийн өөрийн дэлгүүр болон гуравдагч талын жижиглэнгийн борлуулагчдаар дамжуулан борлуулагдадаг.



Баялаг Өлзий компани хөрөнгө оруулалтанд бэлэн болж, улам тэлж, өсөх зорилгоор ТЭЗҮ судалгаа хийсэн.

Өндөр чанартай, найдвартай, тасралтгүй үзүүлдэг үйлчилгээгээрээ дамжуулан тус компани дотоодын зах зээл дээр өсөж, Орос, Европ болон Канад руу экспортлож эхэлсэн. Өнөөдөр, Баялаг Өлзий компанийн бүтээгдэхүүний 90% гаруй хувь экспортонд гарч байна

Компани амжилтанд хүрч байгаа ч хөрөнгө оруулалтанд бэлэн болж чадахгүй, сорил бэрхшээлтэй тулгарч байсан.

Бид тус компанийг Бизнес Экселенс ХХК-н дотоодын зөвлөхтэй холбож өгсөн бөгөөд, тус зөвлөх:

- компанийн одоогийн нөхцөл байдлыг шинжилсэн
- Тухайн салбар болон олон улсын, дотоодын зах зээл, өрсөлдөх чадварыг үнэлсэн.
- Эцсийн хэрэглэгчийн судалгааг хийсэн
- Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, менежментийн тогтолцоонд болон түүхий эдийн ханган нийлүүлэлтэнд гарсан сайжралыг үнэлсэн
- Борлуулалт, маркетинг, хүний нөөцийн менежментийг судлан авч үзсэн
- Санхүүгийн менежмент болон төлөвлөлтийг шинэчилсэн
- Төслийн хэрэгжилтийн болон мониторингийн төлөвлөгөөг боловсруулсан.

Үр дүнд нь Баялаг Өлзий ХХК дотоодын түнш банкнаас эргэлтийн хөрөнгийн зээл авч, экспортын борлуулалтаа нэмэгдүүлж, шинэ цех нээж, ажилчдынхаа тоо нэмсэн.

Борлуулалтын орлого

+215%

Ажилтны тоо

+46%

Экспортын борлуулалт

+21%

Төслийн нийт зардал

€14,100 евро

Үйлчлүүлэгчийн зардал хуваалт

€7,050 евро

www.ebrd.com/knowhow

